



Европын Холбоо
санхүүжүүлэв



Food and Agriculture
Organization of the
United Nations

НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага



U
N
D
P



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН 2023 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН “ХӨТӨЛБӨРТ ЗАРЦУУЛСАН ТӨСӨВ, ХҮРСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН”

2023 он
Улаанбаатар хот



ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ “МОНГОЛ УЛСАД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТОЙ УЯЛДСАН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ НЬ” ТӨСӨЛ

ХӨТӨЛБӨРТ ЗАРЦУУЛСАН ТӨСӨВ ХҮРСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Энэхүү “Хөтөлбөрт зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнгийн тайлан”-г Европын Холбооноос Монгол Улсын Засгийн газарт үзүүлж буй төсвийн дэмжлэгийн бүрэлдэхүүн “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” техник туслалцааны төслийн хүрээнд боловсруулав. Төслийг Европын Холбооны санхүүжилтээр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллагатай хамтран хэрэгжүүлдэг.

НҮБХХ нь ядуурал, тэгш бус байдал болон уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй шударга бус байдлыг эцэслэх зорилго бүхий НҮБ-ын тэргүүлэх байгууллага юм. Дэлхийн 170 орны түншлэгчид болон мэргэжилтнүүдийн өргөн цар хүрээт хамтын ажиллагааны дүнд эх дэлхий, хүн бүрийн сайн сайхны төлөө хөгжлийн урт хугацааны, цогц шийдлийг бий болгоход улс үндэстнүүдийг дэмжин ажилладаг.

Европын Холбоо бол Европ тивийн 27 тусгаар улсын эдийн засаг, улс төрийн нэгдэл юм. Тус Холбоо нь хүний эрхэм чанар, эрх чөлөө, ардчилал, эрх тэгш байдал, хууль дээдлэх ёс, хүний эрхийг түүний дотор цөөнхийн эрхийг дээдлэх үндсэн үнэт зүйлс дээр тулгуурлан байгуулагджээ. Өнөө цагт Европын Холбоо нь даян дэлхийн хүн бүрд хүртээмжтэй, нийгэм, эдийн засаг, байгаль орчны тогтвортой хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаа явуулж байна.

Ерөнхий зүйл: Энэхүү тайлан нь Европын Холбооны санхүүжилтээр боловсруулагдсан. Тайлангийн агуулга зөвхөн зохиогчдын үзэл бодлыг илэрхийлж байгаа бөгөөд Европын Холбоо болон НҮБХХ-ийн албан ёсны бодлого, байр суурийг илэрхийлээгүй. Энэхүү тайланд ашигласан мэдээллийн үнэн зөв эсэх, тухайн материалыг ашигласны улмаас гарах үр дагаварт Европын Холбоо, НҮБХХ хариуцлага хүлээхгүй болно. НҮБХХ-ийн зөвшөөрөлгүйгээр энэхүү хэвлэлийг худалдах, дахин хэвлэх, эсвэл ямар нэгэн ашиг олох хэрэгсэл болгохыг хориглоно.



ӨМНӨХ ҮГ

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ) нь “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” техникийн туслалцааны төслийг Европын Холбооны санхүүгийн дэмжлэгээр хэрэгжүүлж байна.

Төслийн дэмжлэгийн хүрээнд Монгол Улсад бодлого ба төсвийн уялдааг хангах, үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийг ТХЗ-ийн тэргүүлэх салбар, хөтөлбөрүүдэд нэвтрүүлэх, дунд хугацааны зарлагын хүрээнд шилжих бодлогын хувилбарыг тодорхойлохоор ажиллаж байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам төсөлтэй хамтран Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн 2023 оны төсвийн төслийг үр дүнд суурилсан төсөвлөлтийн аргачлалаар боловсруулж, амжилттай туршиж, төсвийг батлуулсан юм.

Төсвийн байгууллагын хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг хангах, болзошгүй эрсдэлийг удирдах, төсвийн зарцуулалтад хяналт тавих, төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх, төсвийн захирагч хооронд байгуулсан гэрээний үр дүнг үнэлж дүгнэхэд чиглэсэн энэхүү “Хөтөлбөрт зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнгийн тайлан”-г боловсруулахад дэмжлэг үзүүлэн ажилласан “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн зөвлөх багийн бүрэлдэхүүн Б.Батбаяр, Г. Түвшинтуяа, Б. Бямбасүрэн нарт талархал илэрхийлье.

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТЭС**



АГУУЛГА

Удиртгал	6
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	7
2.1 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайдын 2023 оны үр дүнд суурилсан төсөвлөлт	9
Хөтөлбөрийн ерөнхий гүйцэтгэл	10
2.1 Хөтөлбөрт зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнгийн тайлангийн хураангуй	11
2.2 Хөтөлбөрийн төсвийн гүйцэтгэл	14
Нийгмийн даатгал	15
Нийгмийн халамж	17
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	21
Хөдөлмөрийн эрүүл ахуй аюулгүй байдлыг сайжруулах	27
Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрүүд	29
Нийгмийн хамгааллын бодлого, удирдлага	36
Тогтвортой хөгжлийн зорилттой уялдсан төсөвлөлт	39
Дүгнэлт	40
Санал	41

ЗУРАГНУУДЫН ЖАГСААЛТ

Зураг 1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайдын бүтэц	8
Зураг 2. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл	11
Зураг 3. Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны сайдын 2023 оны хагас жилийн төсвийн гүйцэтгэл	14
Зураг 4. ХНХЯамны сайдын 2023 эхний хагас жилийн хөтөлбөрийн төсвийн гүйцэтгэл гүйцэтгэл	14
Зураг 5. Нийгмийн даатгал хөтөлбөрийн 2023 оны хагас жилийн арга хэмжээний төсөв, төсвийн гүйцэтгэл	15
Зураг 6. “Нийгмийн даатгалд хамрагдсан ажил олгогчийн тооны өсөлт” -ийн гүйцэтгэл	15
Зураг 7. “Нийгмийн даатгалд даатгуулсан даатгуулагчийн тооны өсөлт”-ийн гүйцэтгэл	16
Зураг 8. Нийгмийн халамж хөтөлбөрийн 2023 оны хагас жилийн арга хэмжээний төсөв, төсвийн гүйцэтгэл.....	17
Зураг 9. “Зорилтот бүлгийн иргэдийг “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-т зуучилж, хамруулсан иргэдийн тоо”-ний гүйцэтгэл	19



Зураг 10. “Нийгмийн халамжийн үйлчилгээний цахимжуулалтын хувь”-н гүйцэтгэл	20
Зураг 11. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн 2023 оны хагас жилийн арга хэмжээний төсөв, төсвийн гүйцэтгэл	21
Зураг 12. “Ажилгүйдлийн түвшин”-ийн гүйцэтгэл	22
Зураг 13. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин”-ийн гүйцэтгэл	23
Зураг 14. Хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээнд хамрагдаж, ажлын байраар хангагдсан орон нутгийн болон зорилтот бүлгийн иргэдийн хувь	24
Зураг 15. Ажлын байрны захиалгад нийцэн шинээр ажилд орсон иргэдийн хувь	25
Зураг 16. “Цалинтай ажиллагчийн цагийн дундаж хөлсний өсөлтийн хувь”-ний гүйцэтгэл	26
Зураг 17. Хөдөлмөрийн эрүүл ахуй аюулгүй байдлыг сайжруулах хөтөлбөрийн 2023 оны хагас жилийн арга хэмжээний төсөв, төсвийн гүйцэтгэл	27
Зураг 18. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын гаралт бууралтын хувь	28
Зураг 19. Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрийн 2023 оны хагас жилийн арга хэмжээний төсөв, төсвийн гүйцэтгэл	29
Зураг 20. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд урьдчилан сэргийлэх болон хамгааллын хариу үйлчилгээ үзүүлсэн хувь	30
Зураг 21. Хүүхдээс хүлээж авсан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь	30
Зураг 22. Хүүхдийн эрхийн зөрчил шийдвэрлэлтийн хувь	31
Зураг 23. Залуучуудын хөгжлийн төвөөр үйлчлүүлсэн залуучуудын эзлэх хувь	32
Зураг 24. Гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр үйлчлүүлсэн гэр бүлийн эзлэх хувь	32
Зураг 25. Ахмадын ордон, өргөө, танхим, төвөөр үйлчлүүлсэн болон зөвлөгөө мэдээлэл авсан ахмад настны хувь.....	33
Зураг 26. Сэргээн засах үйлчилгээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эзлэх хувь	34
Зураг 27. Нийгмийн хамгааллын бодлого, удирдлага хөтөлбөрийн 2023 оны хагас жилийн арга хэмжээний төсөв, төсвийн гүйцэтгэл	36
Зураг 28. Салбарын бодлого, стратеги, тогтолцоог боловсронгуй болгохтой холбоотой шинээр болон шинэчлэн найруулсан хуулийн тоо.....	37
Зураг 29. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь	38
Зураг 30. Хөтөлбөрүүдийн нэгдсэн гүйцэтгэл	41

ХҮСНЭГТҮҮДИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. ХНХЯамны 2023 оны төсвийн тухай хуулийн нэгдүгээр хавсралтын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийг бэлтгэсэн байдал	12
Хүснэгт 2. 2023 оны хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг тогтвортой хөгжлийн зорилттой уялдуулах нь	39

Удиртгал

Монгол Улсын Засгийн газар, Европын холбоо (ЕХ), Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ)-өөс ТХЗ-д нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулахад чиглэсэн төрийн бодлого, төлөвлөлт болон төсөвлөлтийн уялдааг сайжруулах замаар үр дүн, хөтөлбөрт суурилсан төсөв боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, хянах, үнэлэх, тайлагнах тогтолцоо бүхий төсөв, санхүүгийн зохистой удирдлагыг нэвтрүүлэхээр 4 бүрэлдэхүүн хэсэг байгуулан ажиллаж байгаа билээ.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн нэгдүгээр хавсралт болох Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний шалгуур үзүүлэлтийг тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдуулан баталсан.

2023 онд суурь он, суурь түвшний мэдээллийг оруулан баталсан нь үр дүнд гарах өөрчлөлтийг бодитоор хэмжиж “Хөтөлбөрт зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнгийн тайлан” -г тайлагнах боломжийг бүрдүүлээд байна.

Төсвийн хуулийн дагуу хөтөлбөр түүний үр дүнг төсвийн зарлагаар тайлагнах байдал өнгөрсөн хугацаанд чанарын шаардлага хангахгүй байгаа тухай “Төсвийн гүйцэтгэл болон үр дүнгийн тайлагналын өнөөгийн нөхцөл байдлын шинжилгээ”-нд, төлөвлөлт, төсөв, гүйцэтгэлийн уялдаа хангалтгүй байгаа тухай “Бодлогын баримт бичиг болон төсвийн уялдаа” тайланд өгсөн зөвлөмжийн дагуу “Хөтөлбөрт зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнг тайлагнах заавар, маягт” -ын төслийг боловсруулсан.

“Хөтөлбөрт зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнгийн тайлан”-ийн зорилго нь төсвийн байгууллагын хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг хангуулах, болзошгүй эрсдэлийг удирдах, төсвийн зарцуулалтад хяналт тавих, төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх, төсвийн захирагч хооронд байгуулсан гэрээний үр дүнг үнэлж дүгнэх, төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн үр дүнгийн тайланг гаргахад оршино.

Бидний санал болгож буй маягт, аргачлалаар 2023 оны хагас жилийн “Хөтөлбөрт зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнгийн тайлан” -г Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас авсан бөгөөд дараах үр дүнг үзүүллээ.



Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны эрхэм зорилго нь хөдөлмөр, хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын харилцан хамаарал бүхий цогц бодлогыг хэрэгжүүлж, иргэдийн хөдөлмөрлөх, хөгжих таатай орчин бий болгох, нийгмийн баталгааг дээшлүүлэх замаар хүний хөгжлийг хангахад оршино.


Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг, түүний хүрээнд гол зорилтыг хэрэгжүүлнэ:

1. Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын хууль тогтоомжийн төсөл, бодлого, стратеги, хөтөлбөрийн хувилбар, төслийг боловсруулах, салбарын санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн бодлогыг төлөвлөх;
2. Хүн ам, түүний бүлгүүдийн хөгжлийг хангахад чиглэсэн хууль тогтоомжийн төсөл, бодлого, стратеги, хөтөлбөрийн хувилбар, төсөл боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;
3. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, хууль эрх зүйн болон дотоод үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай мэдээлэл, зөвлөгөө, дэмжлэгээр хангах, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх;
4. Хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсрол, сургалтын талаарх хууль тогтоомж, бодлого, стратеги, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хөтөлбөр, төсөл боловсруулж хэрэгжүүлэх;
5. Хөдөлмөрийн харилцааны талаарх хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;
6. Хүн амын нийгмийн баталгааг хангахад чиглэсэн нийгмийн хамгааллын хууль тогтоомж, бодлого, стратеги, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;
7. Салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааны хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, дотоодын хяналт шалгалт, аудит хийх, статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах.



Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны бүтэц


Зураг 1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны бүтэц



2.1 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайдын 2023 оны үр дүнд суурилсан төсөвлөлт

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайдийн 2023 оны үр дүнд суурилсан төсөвлөлтийг хийхэд дараах ахиц, дэвшлүүд бий болсон байна.

- ✓ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт, төсвийн хөтөлбөр хоорондын, арга хэмжээнүүд хоорондын уялдааг зарим хөтөлбөрүүдэд сайжруулсан.
- ✓ Хөрөнгийг илүү үр ашигтай зарцуулах боломжуудыг бодлого тодорхойлогчид хамтдаа харсан. ХНХЯ-ны бодлогын хэрэгжилтийг зохицуулагч, боловсруулагчид (яамны бодлогын зохицуулалт хариуцсан газрын мэргэжилтнүүд) төсөв боловсруулагчийн өнцгөөс, төсвийн ажилтнууд бодлогын мэргэжилтнүүдийн өнцгөөс харж тулгарч буй асуудлуудаа нээлттэй гарган ирж, одоогийн нөхцөл байдалд анализ хийж, хэрхэн илүү үр дүнтэй ажиллах боломж, шийдлийг тодорхойлохыг оролдсон.
- ✓ Яамны ажилтнууд давхацсан, ижил төстэй үйл ажиллагаагаа нэгтгэснээр илүү үр дүнтэй, зардлын хэмнэлттэй ажиллаж болох боломжууд байгааг олж харсан. Жишээ нь: нийгмийн зорилтот бүлэг (ХБИ, Ахмад, Хүүхэд, Гэр бүл залуучуудын газар) бүрд зориулсан үйлчилгээний төвүүдийг орон нутагт тус тусдаа барилгууд барьж, үйл ажиллагаа явуулж буй нь нэгдүгээрт, үйл ажиллагааны тогтмол зардлыг өсгөх, хоёрдугаарт хамтран хэрэгжүүлбэл боломжтой үйл ажиллагааг тус тусдаа хөрөнгө, хүн хүч зарцуулж хийж байна. Үүнийг хүн ам зүйн нэгдсэн бодлогоор харж аль болох үйл ажиллагааг нэгтгэж үр ашигтай, үр шим хүртэгчдээ ээлтэй байдлаар зохицуулах боломж байгааг харсан.
- ✓ Хоорондоо зөрчилтэй хууль, журам, үйл ажиллагаагаа бодлогын хэрэгжилтийг зохицуулагч, боловсруулагчид хамтдаа олж харж хэлэлцүүлэг өрнүүлж, шийдлийг хамтдаа гаргасан, төсөвт нөлөөлж буй нөлөөг харсан. Жишээ нь: Нийгмийн халамж авч буй хүн ХХҮГ-ын үйлчилгээнд хамрагдан түр хугацааны хөдөлмөр эрхлэн нийгмийн даатгал төлөхөөр халамжаас нь хасдаг. Энэ зохицуулалт нь тухайн хүнийг нэг бол албан бус хөдөлмөр эрхлэх эсхүл зөвхөн халамжийн орлоготой байх нөхцөлийг бий болгож байна. Нийгмийн даатгалын орлого өсгөх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, халамжийг бууруулах бодлогуудын хэрэгжилтэд уялдахгүй сөргөөр нөлөөлж байна.



Хөтөлбөрийн ерөнхий гүйцэтгэл




2.1 Хөтөлбөрт зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнгийн тайлангийн хураангуй

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны сайдын 2023 оны төсвийн тухай хуулийн нэгдүгээр хавсралтын хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн 8 (42%) шалгуур үзүүлэлт нь үр дүндээ хүрсэн, 9 (47.4%) шалгуур үзүүлэлт нь сайжруулах шаардлагатай буюу 60%-100%-ийн гүйцэтгэлтэй байна. Харин 2 шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийн мэдээлэл нь хараахан гараагүй байна.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны сайдын 2023 оны хагас жилийн нийт төсөв нь 1,536,834 сая төгрөг бөгөөд үүнээс 1,363,702 сая (88.7%) төгрөгийн төсвийн гүйцэтгэлтэй байна.

Зураг 2. Хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл







Хүснэгт 1. Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны төсвийн тухай хуулийн нэгдүгээр хавсралтын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийг бэлтгэсэн байдал

Хөтөлбөр	Шалгуур үзүүлэлт	Зорилт түвшин	Гүйцэтгэлийн мэдээлэл бэлтгэгдсэн эсэх
Нийгмийн даатгал	Нийгмийн даатгалд хамрагдсан ажил олгогчийн тооны өсөлт /өмнөх жилтэй харьцуулсан хувь/	5.0	Тийм
	Нийгмийн даатгалд даатгуулсан даатгуулагчийн тооны өсөлт /өмнөх жилд харьцуулсан хувь/	2.5	Тийм
Нийгмийн халамж	Зорилтот бүлгийн иргэдийг "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-т зуучилж, хамруулсан иргэдийн тоо /мян.хүн өссөн дүнгээр/	20	Тийм
	Нийгмийн халамжийн үйлчилгээний цахимжуулалтын хувь /хөтөлбөрөөр/	95	Тийм
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	Ажилгүйдлийн түвшин /хувь/	8	Тийм
	Хөдөлмөр эрхлэлтийн түвшин /хувь/	58	Тийм
	Хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээнд хамрагдаж, ажлын байраар хангагдсан орон нутгийн болон зорилтот бүлгийн иргэдийн хувь	40	Тийм
	Ажлын байрны захиалгад нийцэн шинээр ажилд орсон иргэдийн хувь	63	Тийм
	Цалинтай ажиллагчийн цагийн дундаж хөлсний өсөлтийн хувь	33	Тийм
Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг сайжруулах	Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын гаралт бууралтын хувь	6.6	Тийм
Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөр	Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд урьдчилан сэргийлэх болон хамгааллын хариу үйлчилгээ үзүүлсэн хувь	96	Тийм
	Хүүхдээс хүлээж авсан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь	99	Тийм
	Хүүхдийн эрхийн зөрчил шийдвэрлэлтийн хувь	85	Тийм
	Залуучуудын хөгжлийн төвөөр үйлчлүүлсэн залуучуудын эзлэх хувь	45	Тийм
	Гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр үйлчлүүлсэн гэр бүлийн эзлэх хувь	35	Тийм
	Ахмадын ордон, өргөө, танхим, төвөөр үйлчлүүлсэн болон зөвлөгөө мэдээлэл авсан ахмад настны хувь	83	Тийм
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын бодлого, удирдлага	Салбарын бодлого, стратеги, тогтолцоог боловсронгуй болгохтой холбоотой шинээр болон шинэчлэн найруулсан хуулийн тоо	11	Тийм
	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь	90	Тийм



Энэ бүлэгт 2023 оны хагас жилийн хөтөлбөрийн үр дүнг харууллаа. 2023 оны төсвийн тухай хуулийн нэгдүгээр хавсралтын хөтөлбөрийн үр дүнг шалгуур үзүүлэлт бүрийн гүйцэтгэлээр гаргалаа.


Үүнд 4-н түвшний гүйцэтгэл гарсан: гурав нь хүрсэн үр дүнгийн түвшинг эрэмбэлдэг, нэг нь мэдээлэл дутмаг эсвэл хангалтгүйн улмаас амжилтыг эрэмбэлж чадаагүй. Онооны карт нь ногоон, шар, улаан, саарал өнгийн хуваарийг дараах байдлаар ашигладаг.

Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл	
	100%-аас дээш хувийн гүйцэтгэлтэй хөтөлбөрүүд
	60%-100%-ийн гүйцэтгэлтэй хөтөлбөрүүд
	0%-60%-ийн гүйцэтгэлтэй хөтөлбөрүүд
	Шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийн мэдээлэл нь хараахан бэлтгэгдээгүй.

Хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Үр дүндээ хүрсэн	Сайжруулах шаардлагатай	Үр дүндээ хүрээгүй	Мэдээлэл дутуу
Нийгмийн даатгал	2			
Нийгмийн халамж	1	1		
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	2	3		
Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг сайжруулах	1			
Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөр	2	5		
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын бодлого, удирдлага	1	1		
Нийт	9	10	0	


2.2 Хөтөлбөрийн төсвийн гүйцэтгэл

Зураг 3. ХНХ-ын сайдын 2023 оны хагас жилийн төсвийн гүйцэтгэл



ХНХ-ын сайдын 2023 оны эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэлээр нийт орлого 1,478,427 сая төгрөг буюу 99.0 хувийн биелэлттэй, нийт зарлага 1,363,702 сая төгрөг буюу 88.7 хувийн гүйцэтгэлтэй гарсан. (Зураг 3).

Зураг 4. ХНХ-ын сайдын 2023 эхний хагас жилийн хөтөлбөрийн төсвийн гүйцэтгэл



2023 оны төсвийн тухай хуулийн ХНХ-ын сайдын хөтөлбөрүүдийн хүрэх үр дүнгийн тайлан

Дараах хөтөлбөрүүдийн хүрэх үр дүнгүүдийн шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшингүүд нь 2023 оны 12 сарын 31-ээрх хүрсэн байх түвшинг илэрхийлнэ.

Нийгмийн даатгал

Зураг 5. Нийгмийн даатгал хөтөлбөрийн 2023 оны хагас жилийн арга хэмжээний төсөв, төсвийн гүйцэтгэл



Зураг 6. Нийгмийн даатгал хөтөлбөрийн 2023 оны хагас жилийн арга хэмжээний төсөв, төсвийн гүйцэтгэл



Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2023 оны хагас жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээ

Ахиц дэвшил: 2022 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар нийгмийн даатгалд 52.3 мянган ажил олгогч нийгмийн даатгалын шимтгэл төлж байсан бол 2023 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар 54.9 мянган ажил олгогч нийгмийн даатгалын шимтгэл төлж өмнөх оны мөн үеэс 5 хувиар өссөн байна.

Аргачлал: Нийгмийн даатгалд хамрагдсан ажил олгогчийн тооны өсөлт /өмнөх жилд харьцуулсан хувиар/ = (Тухайн жилийн НД-д хамрагдсан ажил олгогчийн тоо-Өмнөх жилийн НД-д хамрагдсан ажил олгогчийн тоо) / Өмнөх жилийн НД-д хамрагдсан ажил олгогчийн тоо*100%

Зураг 7. “Нийгмийн даатгалд даатгуулсан даатгуулагчийн тооны өсөлт”-ийн гүйцэтгэл



Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2023 оны хагас жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээ

Ахиц дэвшил: Нийгмийн даатгалд 2022 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар 1,066,799 даатгуулагч даатгуулж хамрагдаж байсан бол 2023 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар 1,099,213 даатгуулагч хамрагдаж өмнөх оны мөн үеэс 3 хувиар өссөн байна.

Аргачлал: Нийгмийн даатгалд даатгуулсан даатгуулагчийн тооны өсөлт = (Тухайн жилийн НД-д хамрагдсан даатгуулагчийн тоо-Өмнөх жилийн НД-д хамрагдсан даатгуулагчийн тоо)/ Өмнөх жилийн НД-д хамрагдсан даатгуулагчийн тоо*100%

Хөтөлбөрийн нэгдсэн гүйцэтгэл: Нийгмийн даатгал хөтөлбөрийн үр дүнгийн дундаж гүйцэтгэл нь 110%, төсвийн гүйцэтгэл нь 97% мөн хөтөлбөрийн үр ашиг нь 13% байна.

Нийгмийн халамж

Зураг 8. Нийгмийн халамж хөтөлбөрийн 2023 оны хагас жилийн арга хэмжээний төсөв, төсвийн гүйцэтгэл



Зураг 8. Нийгмийн халамж хөтөлбөрийн 2023 оны хагас жилийн арга хэмжээний төсөв, төсвийн гүйцэтгэл



Зураг 9. “Зорилтот бүлгийн иргэдийг “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-т зуучилж, хамруулсан иргэдийн тоо”-ний гүйцэтгэл



Эх сурвалж: ХХҮЕГ-ийн 2023 оны хагас жилийн гүйцэтгэлийн тайлан

Ахиц дэвшил: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн дагуу зорилтот бүлгийн иргэд болох ажил хайгч, ажилгүй, ажилгүйдэлд өртөж болзошгүй, ажил олоход хүндрэлтэй байгаа иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг батлан, хэрэгжүүлэв. 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт 7 хөтөлбөр, 28 арга хэмжээнд 49.7 мянган иргэн хамрагдав.

Хүндрэл, бэрхшээл:

- Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагддаг зорилтот бүлгийн иргэдийн мэдээллийг, Хөдөлмөр эрхлэлтийн цахим систем “e-job”-тэй холбох ажлыг эрчимжүүлэх.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдсан иргэдийн 62.4 хувь нь хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамрагдсан байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нийтлэг үйлчилгээнд хамрагдсан иргэдийг байнгын ажлын байртай болгоход чиглэсэн бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бусад үйл ажиллагаанд хамрагдсан иргэдийг ажлын байраа хадгалж үлдэхэд дэмжлэг үзүүлэх.

Аргачлал: Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагддаг зорилтот бүлгийн иргэдээс хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамруулсан мэдээллийг тайлагнана.

Зураг 10. “Нийгмийн халамжийн үйлчилгээний цахимжуулалтын хувь”-н гүйцэтгэл



Эх сурвалж: ХХҮЕГ-ийн 2023 оны хагас жилийн гүйцэтгэлийн тайлан

Ахиц дэвшил: Одоогийн байдлаар 72 нэр төрлийн үйлчилгээнээс 64 үйлчилгээг цахимжуулсан. Харьяалах яамдад шилжсэн 2 төрлийн үйлчилгээ холбогдох журам гараагүйн улмаас хэрэгжихгүй байгаа 2 төрлийн үйлчилгээ, цахимжих боломжгүй 3, тусгай программаар үзүүлж байгаа 1 төрлийн үйлчилгээ тус тус байна.

Хүндрэл, бэрхшээл:

Төрийн байгууллага хооронд болон хувийн хэвшлийн байгууллагатай мэдээлэл солилцох асуудал маш хүндрэлтэй байна. Төрийн байгууллага болон хувийн хэвшлийн үйлчилгээнүүд нь бүрэн цахим хэлбэрт шилжээгүй, мөн хэрхэн яаж мэдээллээ солилцох арга замыг тодорхойлоогүй байна.

Мөн иргэдийн цахим боловсрол, мэдлэг, ур чадвар дутмаг байгаатай холбоотойгоор хэрэглээтэй хүндрэл чирэгдэл гарсаар байгаа бөгөөд өөрсдөө шууд хандаж мэдэхгүй байгаа тул сум, хорооны нийгмийн ажилтнуудыг ажлын ачааллыг нэмэгдүүлж байна. и-халамж цахим системийн хөгжүүлэлт маш удаашралтай байна.

Нийгмийн халамж хөтөлбөрийн үр дүнгийн дундаж гүйцэтгэл нь 84%, төсвийн гүйцэтгэл нь 90% мөн хөтөлбөрийн үр ашиг нь -6% байна.



Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

Зураг 11. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн 2023 оны хагас жилийн арга хэмжээний төсөв, төсвийн гүйцэтгэл



Зураг 12. “Ажилгүйдлийн түвшин”-ийн гүйцэтгэл



Эх сурвалж: ХХҮЕГ-ийн 2023 оны хагас жилийн гүйцэтгэлийн тайлан

Ахиц дэвшил: 2023 онд Эдийн засгийн өсөлт 5 хувь гарсан болон Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд бүтээн байгуулалтын төслүүд хэрэгжиж эхлэн, ажлын байр нэмэгдсэн. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэнтэй холбоотой ажилгүйдлийн түвшин буурсан байна.

Хүндрэл, бэрхшээл:

Цаашид ажилгүйдлийн түвшинг тогтвортой бууруулахад салбар дундын зохицуулалтыг сайжруулах шаардлагатай байна.

Аргачлал: $\text{Ажилгүйдлийн түвшин} = \frac{\text{Ажилгүй хүний тоо}}{\text{Ажиллах хүч}} * 100\%$



Зураг 13. “Хөдөлмөр эрхлэлтийн түвшин”-ийн гүйцэтгэл

Эх сурвалж: ҮСХ, 2023 оны хагас жилийн ажиллах хүчний судалгаа


Ахиц дэвшил: ХЭҮЗ-ийн 2022 оны 01 дүгээр тогтоолоор баталсан Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр, Аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр, Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, Ногоон ажлын байрыг дэмжих хөтөлбөр, Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн хүрээнд иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. ҮСХ-ны судалгаагаар 2023 оны II улирлын байдлаар 54.5 хувьтай байна.

Хүндрэл, бэрхшээл:

- Хөдөлмөр эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлэхэд салбар дундын зохицуулалтыг сайжруулах
- Бүтээн байгуулалтын төслүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль, эрх зүйн орчныг сайжруулах

Аргачлал: Хөдөлмөр эрхлэлтийн түвшин=Ажиллагчид/Хөдөлмөрийн насны хүн ам×100%

Зураг 14. Хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээнд хамрагдаж, ажлын байраар хангагдсан орон нутгийн болон зорилтот бүлгийн иргэдийн хувь



Эх сурвалж: ХХҮЕГ-ын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн 2023 оны хагас жилийн статистик тайлан


Ахиц дэвшил: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарцуулсан хөрөнгийн хэмжээ өмнөх жилүүдтэй ижил түвшинд байсан хэдий ч ковид-19 цар тахлын дараах үеийн аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаа сэргэсэнтэй холбоотой байна.

Хүндрэл, бэрхшээл:

- Цаашид ажлын байраар хангагдсан иргэдийг ажлын байраа хадгалж үлдэх, ажлын байран дээр суралцах, хөгжих боломжийг бүрдүүлэх чиглэлээр ажиллах.
- 1 ажлын байранд зарцуулж буй дэмжлэгийн хэмжээг нэмэгдүүлж, хөтөлбөрсарга хэмжээний үр дүнг тооноос чанарт шилжүүлэх.



Зураг 15. Ажлын байрны захиалгад нийцэн шинээр ажилд орсон иргэдийн хувь



Эх сурвалж: ХХҮЕГ-ын статистик тайлан "Хөдөлмөрийн зах зээлийн мэдээ"

Ахиц дэвшил: ХЭҮЗ-ийн 2022 оны 01 дүгээр тогтоолоор баталсан Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр, Аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр, Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, Ногоон ажлын байрыг дэмжих хөтөлбөр, Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний дүнд нийт ажилд орсон иргэдийн хувь 58.5 хувьтай гарсан.

Хүндрэл, бэрхшээл:

- Ажилд зуучлах үйлчилгээний хэрэгжилтийг сайжруулах.
- Хөдөлмөрт бэлтгэх сургалтын тогтолцоог сайжруулах, үр дүнтэй сургалт зохион байгуулах.
- Хөдөлмөрийн зах зээлийн онцлог, эрэлтэд нийцсэн хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлэх.
- 1 ажлын байранд зарцуулж буй дэмжлэгийн хэмжээг нэмэгдүүлж, хөтөлбөр, арга хэмжээний үр дүнг тооноос чанарт шилжүүлэх.

Аргачлал: Хөдөлмөр эрхлэлтийн түвшин=Ажиллагчид/Хөдөлмөрийн насны хүн ам×100%

Зураг 16. “Цалинтай ажиллагчийн цагийн дундаж хөлсний өсөлтийн хувь”-ний гүйцэтгэл



Эх сурвалж: ХХҮЕГ-ын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн 2023 оны хагас жилийн статистик тайлан

Ахиц дэвшил: Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хорооны 2022 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаанаар Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2023 оны 1 дүгээр сарын 1-нээс цагт 3273 төгрөг 81 мөнгө, сард 550 мянган төгрөг болгож 31 хувиар нэмэгдүүлэн тогтоосон.


Хүндрэл, бэрхшээл:

- Хөдөлмөрийн тухай хуулиар хүн амын амьжиргааны өртгийн өөрчлөлт, инфляцын түвшнийг харгалзах, ажилтны ур чадварын түвшин, гүйцэтгэл, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулсан байх гэсэн зарчмын дагуу тогтооно. Төр, хувийн хэвшлийн зүгээс тодорхой хэмжээгээр цалин хөлсийг нэмэгдүүлж байгаа ч инфляцын түвшин, үнийн өсөлтийг тогтворжуулах шаардлагатай байна.
- Салбарын олон хуулиар төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны асуудлыг зохицуулж байгаа нь төрийн албаны нэгдсэн цалин хөлсний бодлогыг хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэж байна.
- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг Засгийн газар, ажил олгогч, үйлдвэрчний эвлэлийн төлөөллийн харилцан тохиролцооны үр дүнд шийдвэрлэдэг. ХХДХ-ний нөлөөллөөс шалтгаалан нийгмийн даатгалын шимтгэл төлөгчдийн тоо, хэмжээ, хамралт буурах нөлөөтэй тул одоогийн байдлаар зөвшилцөлд хүрээгүй байна.




Хөдөлмөрийн эрүүл ахуй аюулгүй байдлыг сайжруулах

Зураг 17. Хөдөлмөрийн эрүүл ахуй аюулгүй байдлыг сайжруулах хөтөлбөрийн 2023 оны хагас жилийн арга хэмжээний төсөв, төсвийн гүйцэтгэл



Зураг 18. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын гаралт бууралтын хувь



Эх сурвалж: ҮСХ, 2023 оны 2-р улирлын үйлдвэрлэлийн осол, хурц хордлого

Ахиц дэвшил: 2023 оны 2 дугаар улирлын байдлаар үйлдвэрлэлийн осол хурц хордлогод нийт 125 хүн өртөж, үүнээс 11 хүн нас барсан, 62 хүн хүнд бэртсэн, 52 хүн хөнгөн гэмтсэн байна. Нийт осолд нас баралтын эзлэх хувь 8.4 хувь буюу 12 осол тутмын нэг нь нас баралтад хүргэсэн байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад ослын нийт тохиолдол 39, нас баралт 13, хүнд гэмтэл 16, хөнгөн гэмтэл 10 тохиолдлоор тус тус буурсан үзүүлэлттэй байна. Нийт ослын тоо 23 хувиар буурсан байна. Тус тоон үзүүлэлт нь 2022 оны жилийн эцсийн байдлыг 2023 онгы эхний хагас жилтэй харьцуулсан тоо тул бууралт өндөр хувьтай байна .

Монгол Улсын бүтээн байгууллатын ажлууд 7,8,9 сард идэвждэг тул 2023 оны жилийнн эцсийн тоон үзүүлэлтээр ослын тоо буурах үзүүлэлт багасаж гарах магадлалтай юм.

Аргачлал: Нийт ослын өмнөх оноос буурсан тохиолдлын тоо/Өмнөх оны ослын тохиолдлын тоо*100%

Хөдөлмөрийн эрүүл ахуй аюулгүй байдлыг сайжруулах хөтөлбөрийн үр дүнгийн дундаж гүйцэтгэл нь 348%, төсвийн гүйцэтгэл нь 89% мөн хөтөлбөрийн үр ашиг нь 259% байна.


Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрүүд



Зураг 19. Нийгмийн халамж хөтөлбөрийн 2023 оны хагас жилийн арга хэмжээний төсөв, төсвийн гүйцэтгэл



Зураг 20. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд урьдчилан сэргийлэх болон хамгааллын хариу үйлчилгээ үзүүлсэн хувь




Эх сурвалж: Гэр бүл, хүүхэд, залуучуудын газрын статистик мэдээлэл, тайлан (Айбел программ)

Ахиц дэвшил: Эрсдэлт нөхцөлд амьдарч буй 8,081 хүүхдийн мэдээллийг хүлээн авч, 2,866 хүүхдэд шуурхай тусламж үйлчилгээ, 2,043 хүүхдэд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ, 7,444 хүүхдэд урьдчилан сэргийлэх үйлчилгээ үзүүлж байна.

Аргачлал: Тусламж үзүүлсэн хүүхдийн тоо/Нийт эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоо*100%

Зураг 21. Хүүхдээс хүлээж авсан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь




Эх сурвалж: Гэр бүл, хүүхэд, залуучуудын газрын статистик мэдээлэл, тайлан, А/55 маягт



Ахиц дэвшил: 2023 оны хагас жилийн байдлаар нийт 366 өргөдөл, гомдол хүлээн авсан. Үүнээс хүүхэд өөрөө хандсан 13 өргөдөл байна. Эдгээрийг хугацаанд нь бүрэн шийдвэрлэсэн.

Аргачлал: (Хүүхдээс бичгээр, утсаар, биечлэн ирсэн болон Хүүхдийн элчээр дамжуулан уламжилсан өргөдлийн шийдвэрлэлт)/ (Хүүхдээс бичгээр, утсаар, биечлэн ирсэн болон Хүүхдийн элчээр дамжуулан уламжилсан өргөдлийн тоо)*100%

Зураг 22. Хүүхдийн эрхийн зөрчил шийдвэрлэлтийн хувь



Эх сурвалж: Гэр бүл, хүүхэд, залуучуудын газрын статистик мэдээлэл, тайлан

Ахиц дэвшил: Хүүхдийн эрхийн улсын байцаагчид нийт 59 зөрчлөөс 50 зөрчил шалган 16.1 сая төгрөгийн торгууль ногдуулж шийдвэрлээд байна.

Аргачлал: Шалгагдсан зөрчлийн тоо/ Хүүхдийн эрхийн улсын байцаагчид ирсэн зөрчил * 100%

Зураг 23. Залуучуудын хөгжлийн төвөөр үйлчлүүлсэн залуучуудын эзлэх хувь




Эх сурвалж: Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын захиргааны статистик үзүүлэлт

Ахиц дэвшил: Аймаг, дүүрэг, зарим сумдын Залуучуудын хөгжлийн 43 төвөөр 2023 оны эхний хагас жилд 276,000 залуучууд (15-34 насны залуучуудын 28.5 хувь) хамрагдаж, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан залуучуудын хөгжлийг дэмжих 7 төрлийн арга үйлчилгээ авсан байна.

Аргачлал: Залуучуудын хөгжлийн төвөөр үйлчлүүлсэн залуучуудын мэдээг Б-ЗМ-1 маягтын дагуу ГБХЗХГ улирал бүрийн сүүлийн сарын 20-ны өдрийн дотор ХНХЯ-д цахим болон цаасан хэлбэрээр ирүүлнэ. Залуучуудын хөгжлийн төвөөр үйлчлүүлсэн залуучуудын улирлын мэдээ нь зөвлөгөө өгсөн, холбон зуучилсан, сургалтад хамрагдсан зэрэг үйлчилгээний төрлөөр; хүйсээр, зорилтот бүлгээр; бүсээр, улсын дүнгээр, аймаг, нийслэлийн дүнгээр нэгтгэгдэнэ.

Зураг 24. Гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр үйлчлүүлсэн гэр бүлийн эзлэх хувь



Эх сурвалж: Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын захиргааны статистик үзүүлэлт




Ахиц дэвшил: 2023 оны эхний хагас жилийн байдлаар гэр бүлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд гэр бүлийн боловсрол олгох сургалт, иргэдэд зориулсан нөлөөллийн арга хэмжээ, байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэдэх эцэг, эхийн зөвлөл, эцэг эхчүүдэд чиглэсэн сургалт, арга зүйн дэмжлэг, гэр бүлийг дэмжих хөтөлбөр, явуулын үйлчилгээ зэрэг гэр бүлд чиглэсэн урьдчилсан сэргийлэх үйл ажиллагаанд нийт 355,621 иргэн буюу нийт гэр бүлийн 36.6% нь хамрагдсан байна. Үүнээс 126,404 иргэн гэр бүлд зөвлөгөө өгөх төвийн гэр бүлд зөвлөн туслах, хөгжлийг дэмжих зорилтот үйлчилгээнд хамрагдсанаас гэр бүлийн боловсрол олгох сургалт, хөгжлийн үйлчилгээнд 33,250 эцэг эх, гэр бүлд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээ, үйлчилгээнд 33,350 эцэг эх, хүүхэд хамгааллын үйлчилгээний олон нийтийг мэдлэгжүүлэх зорилтын хүрээнд сургалт, мэдээлэл, хамгааллын үйлчилгээнд 38,134 эцэг эх, гэр бүлд зөвлөн туслах хөгжлийн үйлчилгээнд 21,670 эцэг эх тус тус хамрагдсан байна.

Хүндрэл, бэрхшээл:

- Гэр бүлийн асуудлаар зөвлөгөө өгөх мэргэжлийн хүний нөөц дутмаг: сэтгэл зүйч, нийгмийн ажилтны орон тоо хангалтгүй, чадавхжуулах шаардлагатай,
- Одоо ажиллаж байгаа нийгмийн ажилтны ажлын ачаалал их, тогтвор суурьшил хангалтгүй,
- Иргэдийн зүгээс өөрсдөө гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр үйлчлүүлэхээр санаачилгаараа, сайн дураар ирэх нь ховор, үйлчилгээ авах талаар мэдлэг ч дутмаг. Ихэвчлэн урьдчилсан сэргийлэх үйл ажиллагаа зохион байгуулж иргэдийг хамруулж байна.

Зураг 25. Ахмадын ордон, өргөө, танхим, төвөөр үйлчлүүлсэн болон зөвлөгөө мэдээлэл авсан ахмад настны хувь



Эх сурвалж: Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын захиргааны статистик үзүүлэлт

Ахиц дэвшил: Монголын ахмадын холбоогоор гэрээлэн гүйцэтгүүлж 2023 оны 8 дугаар сарын байдлаар ахмадын өргөө, ордон, төвүүдээр үйлчлүүлсэн болон зөвлөгөө мэдээлэл авсан байна.

Хүндрэл, бэрхшээл:

Ахмадын ордон, өргөө, төвийн үйл ажиллагааг өргөжүүлэх, тогтмолжуулахад дэмжлэг үзүүлж ажиллах хэрэгтэй.

Аргачлал: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагч, Увс аймгийн Засаг даргын хооронд байгуулсан төрийн зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн 2023 онд хэрэгжүүлэх гэрээний 3.37-д "Ахмад настны хөгжил оролцоог дэмжих талаар авах арга хэмжээний болон ахмадын ордон, өргөө байгуулах, тэдний үйл ажиллагаанд зарцуулах төсвийн саналыг боловсруулж, Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэн, ахмадын өргөөг өдөр тутмын идэвхтэй үйл ажиллагаатай байлгаж ахмад настан бүрд нээлттэй байх талаар анхаарч ажиллана" гэж заасан.

Зураг 26. Сэргээн засах үйлчилгээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эзлэх хувь



Эх сурвалж: СЗСҮТөв, ХБХХЕГ-ын статистик тайлан

Ахиц дэвшил: СЗСҮТөв, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвөөр 21,557 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдэд өдрөөр болон хэвтэн эмчлэх үйлчилгээ үзүүлэв.


Хүндрэл, бэрхшээл:

- 1. ЭМДҮЗ-ийн 12-р тогтоолын шалгуур үзүүлэлтийн дагуу манай эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа
 - А. Тархи мэдрэлийн сэргээн засах
 - В. Гэмтлийн сэргээн засах эмчилгээний ор хоног 14 хоногоос дээш г э ж заагдсан учраас нэг орны эргэлт сардаа 2 удаа байгаа.
- 2. ХБИ эмэгтэй 55, эрэгтэй 60 нас хүрээд тэтгэвэрт гардаг, үйлчилгээ авах шаардлага тэтгэвэрт гарснаар багасдаггүй эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан тохиолдолд ахмад гэсэн ангилалд багтдаг.
- 3. Хөдөлмөрийн чадвар алдалт тогтоолгох 90 хоногоосоо өмнө эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан иргэдийн тоо их байдаг.
- 4. Сэргээн засах эмнэлгийн бүтэц орон тоо дутагдалтайгаас эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдал алдагдахад хүрээд байгаа учраас хэвтэн эмчлүүлэх орны тоог 48-50 багтааж байгаа.
- 5. Лавлагаа шатлалын эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахдаа ЭМДҮЗ-ийн 08-р тогтоолын дагуу харьяа өрх, дүүргийн эмнэлгээс 13А маягтай ирэх шаардлага тулгарч байгаа нь амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо буурахад нөлөөлж байгаа.
- 6. Сэргээн засах тусламж үйлчилгээг үзүүлдэг хүний нөөц хомсдол их байна, мөн одоо ажиллаж байгаа албан хаагчдын цалин, урамшуулал хангалтгүй байна.
- 7. СЗЭ-ийн бүтэц орон тоог стандартын дагуу нэмэх
- 8. Улсын хэмжээнд Сэргээн засах тусламж үйлчилгээний үр дүнг таниулах сургалтуудыг чанаржуулах
- 9. СЗЭ-ийн бүтэц орон тоог стандартын дагуу нэмж, эмчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөр үр дүнгийн дундаж гүйцэтгэл нь 92.3%, төсвийн гүйцэтгэл нь 86.5% мөн хөтөлбөрийн үр ашиг нь 5.8% байна.

Нийгмийн хамгааллын бодлого, удирдлага

Зураг 27. Нийгмийн хамгааллын бодлого, удирдлага хөтөлбөрийн 2023 оны хагас жилийн арга хэмжээний төсөв, төсвийн гүйцэтгэл



Зураг 28. Салбарын бодлого, стратеги, тогтолцоог боловсронгуй болгохтой холбоотой шинээр болон шинэчлэн найруулсан хуулийн тоо



Ахиц дэвшил: Нийгмийн даатгалын тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох ҮОМШӨ-ний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулиудыг батлуулсан /шинэчилсэн найруулга/. Төрийн албаны тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулан батлуулсан. Нийгмийн халамжийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Үндэсний баялгын сангийн тухай, Хуримтлалын нэгдсэн сангийн тухай хуулиудын төслийг боловсруулж байна.

Аргачлал: Шинэчлэн боловсруулсан хуулийн төслийн тоогоор хэмжинэ.

Зураг 29. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь

Сайжруулах шаардлагтай



Ахиц дэвшил: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад үүрэг болгосон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 292 заалтын хэрэгжилт 2023 оны эхний хагас жилийн байдлаар 82.1 хувьтай байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад үүрэг болгосон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 292 заалтын хэрэгжилтийг тооцон үнэлэхэд бүрэн хэрэгжсэн 159 заалт, хэрэгжих шатандаа 72 заалт, хэрэгжилт хангалтгүй 38 заалт, хугацаа болоогүй, үнэлэх боломжгүй, бусад байгууллагын эрхлэх асуудлын хүрээний 23 заалт байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын бодлого, удирдлага хөтөлбөр үр дүнгийн дундаж гүйцэтгэл нь 96%, төсвийн гүйцэтгэл нь 86% мөн хөтөлбөрийн үр ашиг нь 10% байна.



Тогтвортой хөгжлийн зорилттой уялдсан төсөвлөлт

Тогтвортой хөгжлийн нийт 17 зорилго, түүний зорилтуудаас Зорилго 1 Ядуурлын эцэс болгох зорилго нь нийгмийн халамж хөтөлбөртэй, Зорилго 8 Зохистой хөдөлмөр, эдийн засгийн өсөлтийг дэмжих нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилготой уялдаж байна.

Хүснэгт 2: 2023 оны хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг тогтвортой хөгжлийн зорилттой уялдуулах нь

Тогтвортой хөгжлийн зорилт		2023 оны төсвийн тухай хуулийн нэгдүгээр хавсралт		2023 оны хагас жилийн төсвийн гүйцэтгэл
	Тогтвортой хөгжлийн зорилго	Хөтөлбөр	Хөтөлбөрийн хүрэх үр дүн	
Ядуурлыг эцэс болгох	Зорилт 1.3. Үндэсний онцлогт тохирсон нийгэм хамгааллын тогтолцоо, бүх хүнд зориулсан нийгэм хамгааллын арга хэмжээ, түүний дотор нийгэм хамгааллын үндсэн үйлчилгээг нэвтрүүлж, түүнд ядуу, эмзэг бүлгийн дийлэнх хэсгийг 2030 он гэхэд хамруулах	Нийгмийн халамж	Зорилтот бүлгийн нийгмийн баталгааг дээшлүүлнэ.	984,212 сая төгрөг
	Зорилт 1.4. 2030 он гэхэд эрэгтэй, эмэгтэй хүн бүр, ялангуяа ядуу, эмзэг бүлгийнхэн эдийн засгийн нөөц боломжийг эрх тэгш хүртэх, түүнчлэн нийгмийн үндсэн үйлчилгээ, газар болон бусад хэлбэрийн эд хөрөнгө өмчлөх, захиран зарцуулах, өв залгамжлах, байгалийн баялаг, зохих шинэ технологи, санхүүгийн үйлчилгээ, түүний дотор бичил санхүүгийн үйлчилгээнд хамрагдах боломжийг бүрдүүлэх.	Нийгмийн халамж	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээний чанарыг сайжруулна. Нийт хүүхдийг хүүхдийн мөнгөн тэтгэмжид хамруулна.	
Зохистой хөдөлмөр, эдийн засгийн өсөлтийг дэмжих	Зорилт 8.5. 2030 он хүртэл эрэгтэй, эмэгтэй хүн бүр тэр дундаа залуу болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бүрэн, бүтээмжтэй ажил, зохистой хөдөлмөр эрхлэх нөхцөлийг бүрдүүлэх.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ. Нийгмийн халамж хүртэгчдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх	31,216 сая төгрөг
	Зорилт 8.6 2020 он гэхэд ажил эрхэлдэггүй, боловсрол эзэмшээгүй эсвэл сургалтад хамрагдаагүй залуучуудын эзлэх хувийг үлэмж хэмжээгээр бууруулах.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	Ажилгүй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.	
	Зорилт 8.8. Бүх ажиллагсад, түүний дотор эмэгтэйчүүд, албан бус хөдөлмөр эрхэлдэг хүмүүсийн эрхийг хамгаалах, эрүүл аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг баталгаажуулах	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	Хөдөлмөрийн харилцааны хүрээнд гарч байгаа маргааны тоог бууруулна.	

Дүгнэлт

Нийгмийн даатгал хөтөлбөрийн хувьд нийгмийн даатгалд хамрагдсан ажил олгогчийн тооны өсөлт болон нийгмийн даатгалд даатгуулсан даатгуулагчийн тооны өсөлт шалгуур үзүүлэлтүүд нь үр дүндээ хүрсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хувьд 2023 онд Эдийн засгийн өсөлт 5 хувь гарсан болон Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд бүтээн байгуулалтын төслүүд хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор ажилгүйдлийн түвшинг 8% болгох зорилтот түвшнээс 6.7% болж үр дүндээ хүрсэн байна. Харин хөдөлмөр эрхлэлтийн түвшин, ажлын байрны захиалгад нийцэн шинээр ажилд орсон иргэдийн хувь гэх шалгуур үзүүлэлтүүд нь үр дүндээ хүрээгүй байна.


Хөдөлмөрийн эрүүл ахуй аюулгүй байдлыг сайжруулах хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хувьд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын гаралтын тоо багассан тул үр дүндээ хүрчээ.

Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрүүдийн хувьд үр дүнгийн 7 шалгуур үзүүлэлт тодорхойлсон бөгөөд дунджаар 92%-ийн гүйцэтгэлтэй байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын бодлого, удирдлага хувьд үр дүнгийн 2 шалгуур үзүүлэлт тодорхойлсон бөгөөд дунджаар 96%-ийн гүйцэтгэлтэй байна.



Зураг 30. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь



Санал

- Ажилд зуучлах үйлчилгээний хэрэгжилтийг сайжруулах
- Хөдөлмөрт бэлтгэх сургалтын тогтолцоог сайжруулах, үр дүнтэй сургалт зохион байгуулах.
- Хөдөлмөрийн зах зээлийн онцлог, эрэлтэд нийцсэн хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлэх.
- 1 ажлын байранд зарцуулж буй дэмжлэгийн хэмжээг нэмэгдүүлж, хөтөлбөр, арга хэмжээний үр дүнг тооноос чанарт шилжүүлэх хэрэгтэй байна.
- “Цалинтай ажиллагчийн цагийн дундаж хөлсний өсөлтийн хувь” шалгуур үзүүлэлт нь дараа жилийн 3-р улирал үндэсний статистикийн хорооноос зарладаг. Иймд тухайн жилийн төсвийн үр дүнг энэхүү үзүүлэлтээр хэмжихэд хүндрэлтэй байна

Хөтөлбөрийн нэр	Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд	Суурь он	Суурь он	2024 оны зорилтот түвшин	Батлагдсан төсөв
Нийгмийн даатгал	Нийгмийн даатгалд хамрагдсан ажил олгогчийн тооны өсөлт /өмнөх жилтэй харьцуулсан хувь/	2021	5.4	5.0	322,093
	Нийгмийн даатгалд даатгуулсан даатгуулагчийн тооны өсөлт /өмнөх жилд харьцуулсан хувь/	2021	2	2.5	
Нийгмийн халамж	Зорилтот бүлгийн иргэдийг “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-т зуучилж, хамруулсан иргэдийн тоо /мян.хүн өссөн дүнгээр/	2021	10	20	1,086,744
	Нийгмийн халамжийн үйлчилгээний цахимжуулалтын хувь /хөтөлбөрөөр/	2021	90	95.0	



Төсвийн гүйцэтгэл	Төсвийн гүйцэтгэлийн %	Хүрсэн түвшин	Гүйцэтгэлийн хувь	Тайлбар
311,541	96.72%	5.0	100%	<p>2022 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар нийгмийн даатгалд 51.8 мянган ажил олгогч нийгмийн даатгалын шимтгэл төлж байсан бол 2023 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар 54.4 мянган ажил олгогч нийгмийн даатгалын шимтгэл төлж өмнөх оны мөн үеэс 5 хувиар өссөн байна.</p>
		3.0	121%	<p>Нийгмийн даатгалд 2022 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар 1,029,922 даатгуулагч даатгуулж хамрагдаж байсан бол 2023 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар 1,061,097 даатгуулагч хамрагдаж өмнөх оны мөн үеэс 3 хувиар өссөн байна.</p>
984,212	90.57%	14.6	73%	<p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэрэгжилт 2023 оны 06 дугаар сарын байдлаар 40,6 хувьтай байгаа бөгөөд үүнээс санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа 42,5-45,8 хувь, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ 33,5 хувь, хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаа, түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагаа 24,0-26,6 хувийн хэрэгжилттэй байна.</p>
		100	105%	<p>Одоогийн байдлаар 72 нэр төрлийн үйлчилгээнээс 64 үйлчилгээг цахимжуулсан ба харьяалах яамдад шилжсэн 2 төрлийн үйлчилгээ, холбогдох журам гараагүйн улмаас хэрэгжихгүй байгаа 2 төрлийн үйлчилгээ, цахимжих боломжгүй 3, тусгай програмаар үзүүлж байгаа 1 төрлийн үйлчилгээ тус тус байна.</p>

Хөтөлбөрийн нэр	Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд	Суурь он	Суурь он	2024 оны зорилтот түвшин	Батлагдсан төсөв
Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөр	Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд урьдчилан сэргийлэх болон хамгааллын хариу үйлчилгээ үзүүлсэн хувь	2021	80.5	96	37,887.2
	Хүүхдээс хүлээж авсан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь	2021	95	99	
	Хүүхдийн эрхийн зөрчил шийдвэрлэлтийн хувь	2021	80	85	
	Залуучуудын хөгжлийн төвөөр үйлчлүүлсэн залуучуудын эзлэх хувь	2021	42	45	
	Гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр үйлчлүүлсэн гэр бүлийн эзлэх хувь	2021	33.9	35	



Төсвийн гүйцэтгэл	Төсвийн гүйцэтгэлийн %	Хүрсэн түвшин	Гүйцэтгэлийн хувь	Тайлбар
32,776.1	86.51	81.0	70%	Эрсдэлт нөхцөлд амьдарч буй 8081 хүүхдийн мэдээллийг хүлээн авч, 2866 хүүхдэд шуурхай тусламж үйлчилгээ, 2043 хүүхдэд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ, 7444 хүүхдэд урьдчилан сэргийлэх үйлчилгээ үзүүлж байна.
		95.0	96%	2023 оны хагас жилийн байдлаар нийт 366 өргөдөл, гомдол хүлээн авсан. Үүнээс хүүхэд өөрөө хандсан 13 өргөдөл байна. / хугацаанд нь бүрэн шийдвэрлэсэн болно./
		99.6	85%	Хүүхдийн эрхийн улсын байцаагчид нийт 59 зөрчлөөс 50 зөрчил шалган / торгууль 16.1 сая төгрөг/ шийдвэрлээд байна.
		28.5	63%	Аймаг, дүүрэг, зарим сумдын Залуучуудын хөгжлийн 43 төвөөр 2023 оны эхний хагас жилд 276000 залуучууд (15-34 насны залуучуудын 28.5 хувь) хамрагдаж, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан залуучуудын хөгжлийг дэмжих 7 төрлийн арга үйлчилгээ авсан байна.
		37.8	108%	Гэр бүлд зөвлөн туслах, хөгжлийг дэмжих үйлчилгээнд нийт 126404 иргэн хамрагдсан байна. Үүнээс: Гэр бүлийн боловсрол олгох сургалт, хөгжлийн үйлчилгээнд 33250 эцэг эх, гэр бүлд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээ, үйлчилгээнд 33350 эцэг эх, Хүүхэд хамгааллын үйлчилгээний олон нийтийг мэдлэгжүүлэх зорилтын хүрээнд сургалт, мэдээлэл, хамгааллын үйлчилгээнд 38134 эцэг эх, гэр бүлд зөвлөн туслах хөгжлийн үйлчилгээнд 21670 эцэг эх тус тус хамрагдсан байна.

Хөтөлбөрийн нэр	Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд	Суурь он	Суурь он	2024 оны зорилтот түвшин	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл
Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөр	Ахмадын ордон, өргөө, танхим, төвөөр үйлчлүүлсэн болон зөвлөгөө мэдээлэл авсан ахмад настны хувь	2021	80	83	37,887.2	32,776.1
	Сэргээн засах үйлчилгээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эзлэх хувь	2021	11.3	20		
Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг сайжруулах	Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын гаралт бууралтын хувь	2021	4.00	6.6	1,276.5	1,133.0
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын бодлого, удирдлага	Салбарын бодлого, стратеги, тогтолцоог боловсронгуй болгохтой холбоотой шинээр болон шинэчлэн найруулсан хуулийн тоо	2021	7	11	3,284.9	2,823.70
	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь	2021	90	90		



Төсвийн гүйцэтгэлийн %	Хүрсэн түвшин	Гүйцэтгэлийн хувь	Тайлбар
86.51	81.0	83.6%	<p>Монголын ахмадын холбоогоор гэрээлэн гүйцэтгүүлж 2023 оны 8 дугаар сарын байдлаар ахмадын өргөө, ордон, төвүүдээр үйлчлүүлсэн болон зөвлөгөө мэдээлэл авсан байна.</p> <p>СЗСҮТөв, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвөөр 21,557 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдэд өдрөөр болон хэвтэн эмчлэх үйлчилгээ үзүүлэв.</p>
88.76	23.0	348%	<p>2023 оны 2 дугаар улирлын байдлаар үйлдвэрлэлийн осол хурц хордлогод нийт 125 хүн өртөж, үүнээс 11 хүн нас барсан, 62 хүн хүнд бэртсэн, 52 хүн хөнгөн гэмтсэн байна. Нийт осолд нас баралтын эзлэх хувь 8.4 хувь буюу 12 осол тутмын нэг нь нас баралтад хүргэсэн байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад ослын нийт тохиолдол 39, нас баралт 13, хүнд гэмтэл 16, хөнгөн гэмтэл 10 тохиолдлоор тус тус буурсан үзүүлэлттэй байна. Нийт ослын тоо 23 хувиар буурсан байна.</p>
85.96	23.0	100%	<p>Нийгмийн даатгалын тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох ҮОМШӨ-ний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулиудыг батлуулсан / шинэчилсэн найруулга/. Төрийн албаны тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулан батлуулсан. Нийгмийн халамжийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Үндэсний баялагын сангийн тухай, Хуримтлалын нэгдсэн сангийн тухай хуулиудын төслийг боловсруулж байна:</p> <p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад үүрэг болгосон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 292 заалтын хэрэгжилт 2023 оны эхний хагас жилийн байдлаар 82.1 хувьтай байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад үүрэг болгосон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 292 заалтын хэрэгжилтийг тооцон үнэлэхэд бүрэн хэрэгжсэн 159 заалт, хэрэгжих шатандаа 72 заалт, хэрэгжилт хангалтгүй 38 заалт, хугацаа болоогүй, үнэлэх боломжгүй, бусад байгууллагын эрхлэх асуудлын хүрээний 23 заалт байна.</p>

